

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 7 ХОНОГИЙН ТАЙЛАН**  
/2022.03.28 - 2022.04.01/

2022.04.01

Дархан-Уул аймаг

№	Ажлын чиглэл	Гүйцэтгэлийн үр дүн
<b>Барилга хот байгуулалтын хэлтэс</b>		
1	Барилгын чиглэл	Засгийн газрын 212-р тогтоолын дагуу 3 барилга байгууламжид ашиглалтад оруулах комиссыг зохион байгуулж ажилласан. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- Дархан сумын 14-р багт байрлалтай “Горгаз” ХХК-ний олон төрөлт түлш түгээх станцын барилга</li> <li>- Хонгор сумын, салхит багт Австри Улсын хөнгөлттэй зээлээр баригдсан 111 ширхэг гэрэлтүүлэг</li> <li>- Ахмадын хорооны их засвар шинэчлэлтийн ажил</li> </ul> Засгийн газрын 213-р тогтоолын дагуу 2 барилга байгууламжид барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг олгосон. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>- Дархан сум, 10-р баг Иргэн Д.Зоригтбаатарын 108-н айлын нийтийн орон сууц</li> <li>- Дархан сум, 14-р баг “Минж проперти” ХХК-ний 60 айлын үйлчилгээтэй орон сууц</li> </ul>
2	Хот байгуулалтын кадастр, зураг төсөл магадлал	-Шинэчилсэн бүртгэлд хамрагдах 52 иргэний өргөдлийг хүлээн авч анхны өмчлөгчийг олж захирамжтай тулгасан. - 44 иргэний мэдээллийг шинэчилсэн бүртгэлд бүрэн оруулсан
<b>Газрын удирдлагын хэлтэс</b>		
1	Суурь судалгаа, газрын мониторингийн чиглэл	<ul style="list-style-type: none"> <li>✓ Хянан баталгаа хийлгэх мэдэгдэх хуудас 3 нэгж талбарт үүсгэв.</li> <li>✓ 7 иргэний цахим хүсэлтийг хүлээн авч гэрээ гэрчилгээг цахимжуулав.</li> <li>✓ Амины орон сууцны зориулалтаар 2009 онд эзэмшүүлсэн 8 нэгж талбарт нөхөн бүрдүүлэлт хийв.</li> <li>✓ Захиалгат хянан баталгааны 4 тайланг хянаж баталгаажуулав.</li> <li>✓ 85 нэгж талбарын хувийн хэрэгт баяжилт хийж архивт хүлээлгэж өгөв.</li> </ul>
2	Геодези, кадастрын чиглэл	Хаягийн зургийн дагуу 17 иргэн, 1 аж ахуйн нэгжийн эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг дугаар олгосон. Шинээр үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахаар /хувийн сууц, гараж, барилга байгууламж/ хэмжилт хийлгэсэн 8 иргэн, 0 аж ахуйн нэгжийн материалыг хүлээн авч мэдээлийн санд оруулж кадастрын зураг гаргасан. Өмчлөх эрхээ бусдад шилжүүлэх хүсэлтээ цахимаар ирүүлсэн 4 иргэний материалыг хянаж өмчлөх эрхийг шилжүүлсэн. Геодези, зураг зүй, кадастрын зураглалын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй “Гео од”, “Ёлт сүрвэй” ХХК-ний хийж гүйцэтгэсэн <ul style="list-style-type: none"> <li>• Цагдаагийн газрын өргөтгөлийн барилга</li> <li>• Шарын гол сумын төвийн хатуу хучилттай авто замын шинэчлэл</li> <li>• “Газ Ойл Нефть” ХХК-ийн түлш түгээх станцын</li> </ul> гүйцэтгэлийн ажлыг шалгаж хүлээн авсан. Сумын Засаг даргын тамгын газрын харъяалалын гүний худгуудын газрын эзэмшигчийн лавалгааг гарган хүргүүлсэн. Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт хийгдэх газар зүйн нэрийн тодруулалтын ажлын төсвийг гарган хүргүүлсэн. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр “Хаягжуулалт” төслийн хүрээнд Дархан сумын 4,5,6,7, Өргөө багуудын нутаг дэвсгэрт хийгдэх гудамж өргөн чөлөө болон барилга байгууламжийн хаягийн тэмдэг үйлдвэрлэх, байршуулах ажлын даалгаварыг хүргүүлсэн. Дархан-Уул аймгийн Дархан суманд байрлах GNSS-ийн байнгийн ажиллагаатай стацад тулгуурлан 811, 5707, 828, 5480 цэгүүд дээр бодит агшины RTK хэмжилт хийж гүйцэтгэн 192.168.20.24 /Geodesy/ GNSS Дархан хавтсанд байршууллаа. Хэмжилтийг геодези, зураг зүйн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй “Ёлт сүрвэй” ХХК-ний СНСNav i80 rover маркийн 2 долгионы GPS багажийг ашиглан хийж гүйцэтгэв.
<b>Захиргаа аж ахуйн чиглэл</b>		

1	Хүний нөөц, дотоод асуудал, хууль эрх зүй	<p><b>Шүүх хурал:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ “Алтан түрүү” ХХК-ны нэхэмжлэлтэй иргэний хэрэгт ГХБХБГ-т холбогдуулж, Дархан сумын 8 дугаар баг, 17 хороололд байрлах газрын дуудлага худалдааны анхны үнийн төлбөр болох 34,360,000 сая төгрөгийг гаргуулах тухай шаардлагын дагуу Газрын даргын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ЗХАМэргэжилтэн Б.Золбаясахыг томилж, хариу тайлбарыг хүргүүлхээр болсон.</li> </ul> <p><b>Сургалт:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>✓ ТАЗөвлөлийн 7:4:10 цагт тогтмол зохио байгууладдаг цахим сургалтаар сургагч багш А.Даваасүрэн “Гүйцэтгэл сайжруулах көучинг хийх нь” сэдвээр хийсэн. Энэхүү сургалтад албан хаагчид zoom-ээр оролцсон.</li> <li>✓ УБ хот, ГЗБГЗЗГ-т зохион байгуулагдах “Барилгын материал, шинэ технологи” үзэсгэлэнд оролцох”, “Нийтийн болон амины орон сууц, хот тохижилт, барилгын материал” үзэсгэлэнд оролцох чиглэлээр БМҮЛХМэргэжилтэн Б.Мөнгөтогос, “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” хэлэлцүүлэгт БХБХэлтсийн дарга Х.Олонбаяр нарын томилолтыг гаргаж, сургалтад хамруулсан.</li> <li>✓ Орхон аймагт “Дахин төлөвлөн барилгажуулах, дэд бүтэцжүүлэх төслүүд” Улсын анхдугаар зөвлөгөөнд БХБХэлтсийн БАХАМэргэжилтэн С.Ундрах, ИДБАХМэргэжилтэн Б.Төмөр, Газрын дарга Д.Батчулуун нар оролцсон.</li> </ul> <p><b>Үүрэг даалгавар:</b></p> <p>“Нээлттэй хаалганы өдөрлөг”-өөр баг болон сумын төвүүд дээр ажиллах өдөр, цагийн хуваарийг гаргаж, нийт албан хаагчдад танилцуулав. 04 дүгээр сарын 08,09-ний өдрүүдэд /Бямба, Ням/ иргэд, ААНБ-дад газрын чиглэлээр үзүүлэх үйлчилгээ, холбогдох зөвлөмж, гарын авлага, төлөвлөгөө зэрэг багтаасан болно.</p>
2	Мэдээллийн технологи, нярав	<p><b>Мэдээлэл:</b></p> <p>70376471 нээлттэй утсаар 15, Facebook хуудсанд ирсэн 8 иргэн, ААНБ-ын асуултанд хариулт өгөв. Байгууллагын цахим хуудасны санал гомдол хэсэгт ирсэн асуултуудыг групп-д байрлуулав.</p> <p><b>Мэдээлэл технологийн чиглэлээр:</b></p> <p>Байгууллагын цахим хуудсанд тавигдсан “Газрын төлбөрийн хувь хэмжээнд санал авах тухай” санал асуулгын үр дүнгийн тайланг хийв. Мэргэжилтнүүдийн хаягийн эхийг 3 хувилбараар бэлтгэв.</p> <p><b>Нярав:</b></p> <p>30 ширхэг Нэгж талбарын хувийн хэрэг нугалав. Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд 31 ширхэг нэгж талбарын хувийн хэргийн хавтас олгов. Агентлагаас ирсэн 10 ширхэг тусгай хэрэгцээний газар ашиглах гэрчилгээг хүлээж авав.</p> <p>Шаардах хуудсаар 1 төрлийн 1 ширхэг бараа материал олгов. 3-р сарын бараа материалын зарцуулалтын нэгтгэлийг гаргаж ня-бод өгөв.</p> <p>Үндсэн хөрөнгийн картын мэдээллийг шинэчлэн кодлож хэвлэхэд бэлэн болгов.</p>

Тайлан боловсруулсан:

Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Б.Золбаясах

Хянасан:

ГУХ-ийн дарга

Г.Нямдорж